
БАТЛАВ:
БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ
ОРЧИН БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

Г.ЭНХМӨНХ

БАТЛАВ:
ӨНДӨРХААН НИСЭХ
БУУДЛЫН ДАРГА

Ц.АМГАЛАНБААТАР

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ХАРЬЯА
ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ӨНДӨРХААН НИСЭХ БУУДЛЫН
2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН.**

Регистрийн дугаар: 2628546

ХЯНАСАН: БОАЖЯ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН
УДИРДЛАГЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН/П.ШИНЭЦЭЦЭГ/

БОЛОВСРУУЛСАН: ӨНДӨРХААН НИСЭХ БУУДЛЫН ШАТАХУУНЫ
НЯРАВ, ЛАБОРАНТ /П.ТӨРМАНДАХ /

2024 он

1. Төслийн товч танилцуулга

Төслийн нэр	Хэнтий аймаг дахь Өндөрхаан нисэх буудал
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Монгол Улс, Хэнтий аймаг, Хэрлэн сум, 1 дүгээр баг
Утас, факс	Утас: 976-71-281205, 976-70562524 Факс: 976-70562524
Шуудангийн хаяг	Монгол Улс, Хэнтий аймаг, Хэрлэн сум, 23123
Цахим хаяг	Khentii.airport@mcaa.gov.mn
Аэродромын код	ZMUN
Аэродромын хяналтын код	G
Аэродромын байрлал	Хэнтий аймгийн Чингис хотоос баруун зүгт 2.9км зайд байрлана. Өргөрөгийн 47°18'16" уртрагийн 110°36'32" оршдог. Аэродромын өндөр 1039м
Газар эзэмших гэрчилгээ	Газар эзэмших эрхийн 0298502 тоот дугаартай гэрчилгээ бүхий 1047099 м ² газрыг агаарын хөлөг хөөрч буух зориулалтаар 60 жилийн хугацаатай эзэмшинэ.
Аюулгүйн бүс	Аймгийн засаг даргын 2020.11.09-ний өдрийн А/907 дугаар захирамж, Хэрлэн сумын засаг даргын 2009 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 98 дугаар захирамжаар Нисэх буудлын аюулгүйн бүсийг баталгаажуулсан.
Төслийн хүчин чадал	Өндөрхаан нисэх буудал нь 1958 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байгаа. 60х40 метр хэмжээтэй цемент бетон перрон зогсоолтой.

2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт

Хэнтий аймаг дахь “ӨНДӨРХААН” нисэх буудал нь Хэнтий аймгийн Хэрлэн сумын 1-р багийн нутагт байрлана.

Хэнтий аймаг 1923 онд байгуулагдсан. Газар нутгийн хэмжээ - 80,311 км² (21 аймгаас 9-р том^[2]). 2021 оны тооцоогоорх хүн амын тоо - 78100.. Засаг захиргааны төв - Чингис хот. Аймаг нь засаг захиргааны хувьд 17 сум нэгжтэй.

Хэнтий аймаг Монгол орны дорно умар биед оршино. Хэрэглээний бүсчлэлээр зүүн бүст хамаарна. Хойд талаараа Оросын Холбооны Улстай (Өвөр Байгалийн хязгаар) хил залгана. Улс дотор Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр, Төв, Сэлэнгэ гэх 6 аймаг, улсын нийслэлийн Багануур дүүрэгтэй хиллэнэ.

Уур амьсгалын хувьд аймгийн жилийн дундаж агаарын температурын тархалтын зургаас үзвэл агаарын температур +2⁰-2⁰ хооронд тэгш хэмтэй хэлбэлзэнэ. Өвлийн улиралд дунджаар 5-6 см зузаантай цас ордог. Салхины зонхилох чиглэл нь ихэвчлэн баруун өмнөөс байдаг ба хаврын улиралд /4,5 дугаар саруудад/ улиралд ихэвчлэн салхи ихтэй байдаг.

3. ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Агаарт үзүүлэх сөрөг нөлөөлөл. Өндөрхаан нисэх буудал нь Хэрлэн сумын төвтэй харьцангуй ойр зайд буюу баруун урагш 3 км орчим зайд байрладаг ч агаарын чанарын нарийвчилсан судалгааны үр дүнгээр сумын суурьшлын бүсэд үүсдэг агаарын бохирдол аэродромын үйл ажиллагаанд нөлөөлөл үзүүлэхээргүй байна (Төслийн байгаль орчны төлөв байдлын тайлан). Энэ нь нутаг дэвсгэрийн салхины онцлогтой холбоотой юм.

Нисэх буудал нь тогтмол нислэггүй тул төслийн талбайн хэмжээнд үүсэх агаар бохирдуулах бодисуудын болон хүлэмжийн хийн ялгарлын хэмжээ нь нисэх буудлын цогцолборын усан халаалтыг зуухнаас үүснэ гэж үзсэн. Шатахууны агуулах, аварын үед ашиглах дизель генератор, технолгийн машин тоног төхөөрөмжүүд зэрэг бусад эх үүсвэрээс хүрээлэн буй орчны агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл нь маш бага гэж үзсэн. Иймд усан халаалтын зуухнаас ялгарах бохирдуулах бодисуудын хэмжээг бууруулах нь төслийн сөрөг нөлөөллийг бууруулах үндсэн арга хэмжээ болно. Нисэх буудалд одоо ашиглагдаж байгаа усан халаалтын зуух нь БНХАУ-д үйлдвэрлэгдсэн 75кВт хүчин чадалтай зуух бөгөөд утаа шүүх ямар нэг систем суурилагдаагүй, зуухнаас ялгарах голлох агаар бохирдуулах бодисууд нь тоос тоосонцор, хүхэрлэг хий байна.

Дуу шуугиан үүсгэх сөрөг нөлөөлөл: Агаарын хөлгөөс гадна нисэх буудалд ашиглагдаж буй машин тоног төхөөрөмжүүд, цахилгаан генератор зэрэг нь дуу чимээ үүсгэгч эх үүсвэр болно.

Агаарын хөлгөөс үүдэлтэй дуу чимээг бууруулах нь нэлээд төвөгтэй тул орон нутгийн зэрлэг ан амьтдын тархалт нутагшилд ямар нэг нөлөөлөл үзүүлдэг эсэхийг судалж шаардлагатай тохиолдолд нислэг үйлдэхийг хориглосон бүсүүдийг тогтоох хэрэгтэй.

Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл. Нисэх буудлын өргөтгөлийн үйл ажиллагаанаас 12 га талбайд шимт хөрс 20 см, шимэрхэг хөрс 20-35 см-т тархаж байх тул хөрс хуулалтыг 30-35 см-ээр хийхэд байгалийн нягтаар 42.0 мянган м³, сийрэгжсэн нягтаар 50.4 мянган м³ хөрсийг түр хугацаагаар хадгалах шаардлагатай болно.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ:

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь нисэх буудал байршиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, БОННУ-н дэх зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагаанаас үүсч буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төлөвлөгөө хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч Иргэний Нисэхийн Үндэсний Төвийн харъяа “ӨНДӨРХААН” нисэх буудлын удирдлагын заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, БОАЖЯ-наас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагын дагуу боловсруулсан болно.

Энэхүү төлөвлөгөөнд тусгасан байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүд нь зөвхөн Иргэний Нисэхийн Үндэсний Төвийн харъяа “ӨНДӨРХААН” нисэх буудлын үйл ажиллагаанд зориулагдсан.

5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал	Төлөвлөгөөний хэрэгжилт
1. Агаар орчин							
Агаар бохирдуулах бодисуудын болон хүлэмжийн хийн ялгарлын хэмжээ нь нисэх буудлын усан халаалтыг зуухнаас үүснэ. Нисэх буудлын барилгыг Кувейтийн сангийн хөрөнгө оруулалтаар шинэчлэх ажил хийгдэж байгаа	Мэргэжлийн байгууллагаар тогтмол ачиж зайлуулж төвлөсөн цэгт хаях	Нисэх буудал орчимд	88000	88000 х 6 удаа = 528000	Сар тутам	- Агаарын тухай хууль, - MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд)	Аймгийн Хот тохижуулах газартай гэрээтэй ажиллан сар бүр хогийг төвлөрсөн цэгт хаяуулдаг. Хавсралт зураг 1. Оффис болон тоног төхөөрөмжийн өрөө бүрт орчны агаарын чийглэг, температур хэмждэг багаж байрлуулсан. Хавсралт зураг 2. Хавсралт зураг 3.
	Агаар дахь хорт бодисын хэмжээг ЗДХээс хэтрүүлэхгүй байх, ажлын байрны агаарын температур,	Нисэх буудал орчимд					

	гэрэлтүүлэг, чийглэгийн хэмжээг хянаж, стандартад заасан хэмжээнд байлгах						
2. Усны нөөц, чанар							
Унд ахуйн зориулалтаар ус хэрэглэх тул усны нөөц хомсдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна	Ахуйн болон хэрэглээний ундны усанд тогтмол хяналт тавьж байх	Нисэх буудлын гар худаг, гүний худаг орчим	--*--	--*--	Өдөр бүр.	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль	Ахуйн болон хэрэглээний ундны усанд тогтмол хяналт тавьж ажиллаж байгаа ба харуул өдөрт 2 удаа объектыг тойрч эргэдэг. Хавсралт зураг 4.
3. Хөрс ургамлан бүрхэвч							
Газрын тосны бүтээгдэхүүний агуулахаар хөрс бохирдох	Шатах тослох материалаар машин техникийг цэнэглэхдээ ШТМ алдагдсан үед хөрсөнд нэвчихээргүй байх аюулгүй ажиллагааны арга хэмжээ авч байх.	Шатахууны агуулахын эргэн тойронд, перон талбай	200000	200000	Тухай бүр	MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	Зориулалтын бетон талбайд машин техникийг цэнэглэдэг учир хөрсөнд бохирдол үүсдэггүй. Хавсралт зураг 5. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу ХАБ-ын инженер өдөр бүр зааварчилгаа өгдөг.

							Хавсралт зураг 6.
	Техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагаанд хяналт тавих	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу	--*--	--*--	Өдөр бүр		
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд нийт 1256000 төгрөг төсөвлөв.							

6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал	Төлөвлөгөөний хэрэгжилт
1	Зүлэгжүүлж, цэцэг тарих	Олон настын үр авах	Барилгажаагүй талбайд	36	Нисэх буудлын өдөр тутмын үйл ажиллагаагаар зохицуулагдаж, үйл			MNS 5973:2009, Барилга байгууламж, инженерий	Байгууллагын цэцэрлэгжилт,ногоон байгууламжийн хүрээнд байгууллагын хашаанд ажилчид цэцгийн мандал тарьж ургуулсан ба үр худалдан авсан баримтыг хавсаргав.
	Машин механизмын явалт, тоног төхөөрөмжийн нөлөөгөөр	Ашиглагдаж буй түр зам, бусад байгууламжуудын орчимд тэмдэг тэмдэглэгээ		-					

2	хөрс нягтарч, доош суух доройтох, элэгдэж эвдрэх, зулгарах, физик шинж чанар нь алдагдсанаар хөрс хуурайших, хөрсний биологийн нөөц хомстох, үржил шим нь алдагдах,	тавих, олон салаа зам гаргахгүй байх талаар арга хэмжээ авах	Нисэх буудал орчимд		ажиллагааны зардлаар хийгдэнэ 250000	5 сарын1 - нээс 6-р сарын 15- ны хооронд	н шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламж ийн ойртох зай хэмжээ	Хавсралт зураг 7. Хавсралт зураг 8. Хавсралт зураг 9. Хөрс эвдэж олон зам гаргахыг зогсоох үүднээс нисэх буудалруу чиглэл заасан тэмдэг болон зогсоолын тэмдэглэгээг байрлуулсан. Хавсралт зураг 10. Хавсралт зураг 11.
3	Техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах	Мазын граж болон дизелийн өрөөний гаднах үзэмж болон мөөгөнцөрдсөн таазыг засварлах	M2	60	500000	6-р сарын 1-ний дотор		Мазын граж, дизелийн өрөөний гадна тал болон мөөгөнцөрдсөн хэсгийг засварлаж янзалсан. Хавсралт зураг 12. Хавсралт зураг 13.
								Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд Хэрлэн

4	“Тэр бум” мод үндэсний	Шилмүүст мод тариалах	0,3га	50	750000	5-р сарын 25-ний дотор		сумаас зохион байгуулсан үйл ажиллагаанд хамт олноороо оролцож мод тарьсан ба суулгац худалдан авсан баримтыг хавсаргав. Хавсралт зураг 14. Хавсралт зураг 15.
	Нийт				1500000 төг			

7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал	Төлөвлөгөөний хэрэгжилт
1.	Төслийн орчинд түүх соёлын өвд хамаарагдах эд өлгий байхгүй.	0	0	0	0	0	0	0	0
	Нийт								

8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах стандарт, аргачлал	Төлөвлөгөөний хэрэгжилт
1	Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Ангилдаг хогийн сав суурилуулах	Нисэх буудал орчимд	М.ку б	300000	1	300000	2024 онд	Хог хаягдлын тухай хууль, Ариун цэврийн тухай хууль болон байгаль орчны багц хуулиуд, холбогдох дүрэм, журам стандарт	Нисэх буудлын оффисын орчимд Аюултай химийн гаралтай,хоолны,дахин боловсруулах,бусад 4 ангилдаг хогийн сав байрлуусан. Хавсралт зураг 16.
2	ШТМ хадгалах сав,шугам хоолойг цэвэрлэхэд зарцуулагдах ТС-1 шатахууны тунадас	ТС-1 шатахууны тунадасыг журмын дагуу устгаж аюулгүй болгоно.	Нисэх буудал, шатахууны агуулах	Литр /350 л ТС-1/	780000	1	780000	Тухай бүр	.	8-р сард 2024 оны шатахууны үйлчилгээ ирсэн.Гарсан шатахууны тунадасыг 200 литрийн саванд хийж нөөцийн агуулахад хадгалдаг. Хавсралт зураг 17. Хавсралт зураг 18.
НИЙТ							1080000 төг			

9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналлтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давт амжийн тоо	Нэгжийн зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Тайлбар	Баримтлах стандарт, аргачлал	Төлөвлөгөөний хэрэгжилт
1	Нисэх буудлын орчны шувуудын нягтшил, сүрэглэл, зүйлийн ажиглалтыг хийж бүртгэл хөтлөх	Нисэх буудлын орчны бүсэд 15 км-ийн радиуст ХБЗ-ний оролт, гаралтын дагууд тус бүр 2 цэгт	Сар бүр	12	Нисэх буудлын өдөр тутмын үйл ажиллагаагаар зохицуулагдаж, үйл ажиллагааны зардлаар хийгдэнэ		ИНЕГ-ын шууд удирдлагаар хянагдаж, баталгаажиг байна.	И Н Е Г - а а с баталсан шувууны менежментийн баримт бичиг Нисэх буудлын дотоод хяналтын баримт бичгүүд	7 хоног бүр бүртгэл хөтөлж байгаа ба ажлын өдөр бүр нисэх буудлын ойр орчмын шувууны мэдээг ИНУТ-ын ИНБУГ-ын шувууны мэдээг хариуцсан мэргэжилтэнд мэдээлдэг.
2	Ан амьтнаас үүдэлтэй осол, осол дөхсөн тохиолдлын бүртгэл хийх	Аэродром дээр болсон ослын бүртгэл	Тухай бүр	12					Нислэгийн зөрчлийн бүртгэлийн журналыг журмын дагуу хөтлөн ажиллаж байгаа.
	Нийт								Хавсралт зураг 19.

10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь /2024 онд/				Хариуцсан албан тушаалтан	Төлөвлөгөөний хэрэгжилт
			1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал		
1	Цаг уурын урьдчилсан мэдээллийг тогтмол авч, үйл ажиллагаатайгаа уялдуулах	0	Төлбөргүй	Төлбөргүй	Төлбөргүй	Төлбөргүй	Цаг уурын ажиглагч	Ус цаг уурын орчин шинжилгээний төвтэй хамтран ажиллах гэрээний дагуу цаг агаарын бодит болон урьдчилсан мэдээг өдөр бүр авч үйл ажиллагаандаа ашигладаг. Хавсралт зураг 20
2	ШТМ-ыг хадгалах сав, тээвэрлэх тээврийн хэрэгсэл, улмаар ажилтан албан хаагчдын мэдлэг чадварт тогтмол хяналт тавьж, шалгах	0	Төлбөргүй	Төлбөргүй	Төлбөргүй	Төлбөргүй	Нисэх буудлын дарга	Шатахууны лаборант 2 жил тутамд сургалтанд суудаг ба хяналт шалгалтыг дотоод хяналтын үзлэгийн хуудсаар хөтлөгдөж байгаа. Хавсралт зураг 21. Хавсралт зураг 22.
	Аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний	0	Төлбөргүй	Төлбөргүй	Төлбөргүй	Төлбөргүй	ХАБЭА-н ажилтан	Галын аюулаас сэргийлэх сургалтыг танхимаар болон дадлагаар 2 өдрийн сургалт хийсэн.

3	талаар мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авах							Хавсралт зураг 23.
4	Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг мэргэжлийн байгууллагаар тогтмол хийлгэх	200,0	--*--	100,0	--*--	100,0	ХАБЭА-н ажилтан	Аймгийн 300НЗ өвчин судлалын төвтэй гэрээ байгуулж тогтмол ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлгэж байгаа. Хавсралт зураг 24.
	Дүн	200,0		100,0		100,0		

11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ, БОМТ-ны хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа	Хариуцсан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар	Төлөвлөгөөний хэрэгжилт
	1	2	3	4	5	6	7
1.	Орон нутгийн иргэд	Цахим хэлбэрээр	Орон нутгийн иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх	11-12 сард	Аюулгүй байдлын ажилтан бичиг хэрэг	Өндөрхаан Нисэх буудал	Орон нутгийн иргэдэд цахим хэлбэрээр болон биечлэн тайлагнасан. Хавсралт зураг 25.

2.	Сумын ЗДТГ-ын удирдах албан тушаалтнууд, Нисэх буудлын дарга, холбогдох ажилтнууд	Уулзалт	Байгаль хамгаалахад сумын холбогдох ажилтнуудын оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөн зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОМТ-нд тусгах	11-12 сард	Шатахууны нярав лаборант	Хэрлэн сумын ЗДТГ	Сумын ЗДТГ-ын удирдах албан тушаалтнуудад нисэх буудлын дарга, холбогдох ажилтнуудтай тайланг танилцуулсан. Хавсралт зураг 26.
3.	Хэнтий аймгийн БОАЖГазарт	Ажлын хэсэгт танилцуулах ,хамгаалах	Төлөвлөгөөний хүрээнд	11 сарын 1-ний дотор	Шатахууны нярав лаборант	Өндөрхаан Нисэх буудал	Хэнтий аймгийн БОАЖГазарт 2024 оны БОМТ-ний тайланг холбогдох ажилтнуудын хамт тайланг тавьж хамгаалсан. Хавсралт зураг 27.
	Нийт			Үйл ажиллагааны зардлаар хийгдэнэ			

Хавсралт зураг 1.



Хавсралт зураг 2.



Хавсралт зураг 3.




Хавсралт зураг 4.



Хавсралт зураг 5.



Хавсралт зураг 6.



Хавсралт зураг 7.



Хавсралт зураг 8.



Хавсралт зураг 9.

НХМаягт БМ-3

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт

ЗАРЛАГЫН БАРИМТ №

Цагаан булаг Аж Ахуй (байгууллагын нэр) Нисэх (худалдан авагчийн нэр)

Регистрийн № Регистрийн № 2628544

2024 оны 10 сарын 01 өдөр (тээвэрлэгчийн хаяг, албан тушаал, нэр)

№	Материалын үнэт зүйлийн нэр, зэрэг, дугаар	Код	Хэм-жих нэгж	Худалдах		
				Тоо	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Шууд мур		м	50	15000	750000
2	Сон шон ургамал		м	36	1500	54000
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						
11						
12						
13						
14						
15						
16						
17						
18						
19						
20						
	Дүн					804000

Хүлээлгэн өгсөн эд хариуцагч:
Хүлээн авагч
Шалгасан нягтлан бодогч

Тэмдэг

ЦАГААН БУЛАГ
ХХК
УТ57472 419106

Хавсралт зураг 10.



Хавсралт зураг 11.



Хавсралт зураг 12.



Хавсралт зураг 13.




Хавсралт зураг 14.



Хавсралт зураг 15.



Хавсралт зураг 16.




Хавсралт зураг 17.



Хавсралт зураг 18.



Хавсралт зураг 19.



Хавсралт зураг 20.



Хавсралт зураг 21.



Хавсралт зураг 23.



Хавсралт зураг 24.



Хавсралт зураг 25.



Хавсралт зураг 26.



Хавсралт зураг 27.